

**“МОН-ИТ БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 04 сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 14:00 цагт ковидын нөхцөл байдлаас шалтгаалан онлайнгаар хуралдлаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг Өнөөдөр сонин болон Өдрийн сонины 2021 оны 03 сарын 15-ний өдрийн болон 2021 оны 03 сарын 30-ний өдрийн дугаарт тус тус нийтлүүлэн Хувьцаа эзэмшигчдэд хүргэв.

Хурлыг Хувьцаа эзэмшигч Б.Анхболд даргалав.

Хурлыг эхлүүлэхээр хурлын тооллогын комиссын дарга Б.Баянжаргал ирцийн мэдээг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Б.Баянжаргал: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. “Мон-Ит Булигаар” ХК-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн мэдээг мэдээллэе. 2021 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн ээлжит хуралд компанийн нийт 400212 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг төлөөлж 352627 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаа, нийт хувьцааны 88.1 хувийн хувьцаа эзэмшигч нар хүрэлцэн ирсэн байна. Иймд компанийн хуулийн 69-р зүйлийн 69.1-д зааснаар хурлын ирц бүрдэж байгаа учир хурал хүчин төгөлдөр нээж байгааг мэдэгдэе.

А.Энхмэнд: За ингээд Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя.

Нэгдүгээрт: “Мон-Ит Булигаар” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.

Хоёрдугаарт: “Мон-Ит Булигаар” ХК-ны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг /кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн/-ийг 1 жилийн хугацаатайгаар сонгох.

Б.Анхболд: Сайн байцгаана уу. Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ, та бүхний амар амгаланг айлтгаж, энэ эрсдэлт цаг үед эрхэм дээд эрүүл мэнд, энх тунхыг хүсэн ерөөе. “Мон-Ит Булигаар” ХК нь Монголын арьс ширний салбарын хамгийн анхны бөгөөд томоохон үйлдвэрлэгч компанийн нэг билээ. 2020 оны цар тахалтай энэ хүнд үед манай компани нь үйл ажиллагаа болон хүний нөөцийн хувьд эрсдэл багатай даван тууллаа. Иймд энэ удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж та бүхэнд өөрсдийн ажлыг танилцуулан хэлэлцэхдээ таатай байна. Бидний үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүйг ХЭХ-ийн материалаас уншиж танилцах боломжтой. /Компанийн үйл ажиллагааны тайланг presentation-ээр үзүүлэн нэг бүрчлэн дэлгэрэнгүй уншиж танилцуулав./

А.Энхмэнд: Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд болон ТУЗ-ийн дүгнэлтийг та бүхэнд танилцуулая.

Та бүхэн presentation-рүү анхаарлаа хандуулна уу. /ТУЗ-ийн дүгнэлтийг ТУЗ-ийн дарга А.Энхмэнд нэг бүрчлэн дэлгэрэнгүй уншиж танилцуулав./

А.Энхмэнд: За баярлалаа. Эргээд хэлэлцэх асуудалдаа ороё. “Мон-Ит Булигаар” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах эсэх.

Мөн ТУЗ-ийн гишүүд /кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн/-ийг 1 жилийн хугацаатайгаар сонгох уу. Та бүхэн тарааж өгсөн ХЭХ-ийн материалиас харж болно.

А.Энхмэнд: Баярлалаа. Та бүхэнд тараасан материалын хамгийн сүүлийн хуудсан дээр санал авах хуудсны дагуу та бүхэн саналаа өгөх болно. Та бүхэн материалтайгаа дахин нэг сайн танилцаад санал авах хуудсаа бөглөж өгөх байгаа. Саналын хуудас бөглөх зааврыг манай тооллогын комиссоос танилцуулнаа.

Тооллогын комисс: За компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох асуудлыг санал хураах кумулятив аргаар явуулах байгаа. Кумулятив арга гэдэг нь танд байгаа нийт хувьцааны тоог нэр дэвшигчдийн нийт тоогоор үржүүлэн тооцсоноор таны санал өгөх нийт эрхийн тоо гардаг байгаа. Та бүхэнд санал хураах асуудлаар ойлгомжгүй зүйл, асуух асуулт байвал асууж болно.

А.Энхмэнд: За саналаа өгсөн та бүхэнд баярлалаа. Одоо манай тооллогын комиссоос санал хураалтын дүнг танилцуулна.

Тооллогын комисс: “Мон-Ит Булигаар” ХК-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал асуулгын дүн нэгтгэгдэн гарсан байна. Хуралд оролцогч нийт хувьцаа эзэмшигчдийн 88,1 хувийн саналаар 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн баталсан байна. Мөн дараагийн асуудал ТУЗ-ийн гишүүдийг /кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн/-ийг 1 жилийн хугацаатайгаар 88.1 хувийн саналаар сонгогдсоныг тус тус Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан танилцуулан батлуулъя.

Б.Анхболд: За баяр хүргэе. Өнөөдрийн манай Хувьцаа эзэмшигчдийн хурал хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууслаа. Хуралд оролцсон та бүхэнд маш их баярлалаа. ТУЗ-ийн цаашдын ажилд амжилт хүсэе.

Хувьцаа эзэмшигчдийн хурал 14 цаг 40 минутанд дуусав.

Танилцсан: Хурлын дарга

Тэмдэглэл хөтөлсөн:



Б.Анхболд

Б.Баянжаргал